UPI URBAN PLANNING INSTITUTE

# ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭЛЭН ХХК
## URBAN PLANNING INSTITUTE









- Хот байгуулалт, төлөвлөлт
  - Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
  - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
  - Барилгажилтын төсөл, хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл
  - Төсөл, хөтөлбөр, ТЭЗҮ
- Барилгын зураг төсөл, гадна шугам сүлжээ, тохижилт
- Интерьер, экстерьер
- Зураг төсөл зохиогчийн хяналт
- Захиалагчийг төлөөлөн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх




Тус компани нь хот төлөвлөлт, барилгын зураг төсөл, интерьер, экстерьер, тохижилт, барилга угсралт, реклам чимэглэл, барилгын материалын худалдааны чиглэлээр 2000 оноос үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд 2012 оноос Хот байгуулалт, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах чиглэлээр дагнасан "Хот төлөвлөлтийн хүрээлэн" ХХК-г байгуулж өөрийн өмчлөлийн байр, программ хангамж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан, архитекторууд, бүх төрлийн инженерүүд, хот төлөвлөгч эдийн засагчид, төсөвчин зэрэг мэргэжлийн инженер техникийн ажилтнуудын баг хамт олныг бүрдүүлэн салбартаа амжилттай ажиллаж байна.

Захиалагч, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хүсэл эрмэлзэл, санал санаачлагад тулгуурлан хот байгуулалтын баримт бичиг, бүх төрлийн барилга байгууламж, инженерийн хангамжийн иж бүрэн зураг төслийг суурь судалгаа, холбогдох хууль тогтоомж, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулж төслийн хэрэгжилтийн шатанд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэж захиалагч, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийн харилцан хамаарал уялдаа холбоог хангаж ажилласнаар улс орны бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулах нь бидний ЭРХЭМ ЗОРИЛГО бөгөөд энэхүү зорилгоо биелүүлэн ажиллахад мэдлэг боловсрол, мэргэжлийн өндөр ур чавдартай орчин үеийн программ хангамж, техник хэрэгслийг бүрэн эзэмшсэн баг хамт олон манай компаний ҮНЭТ ЗҮЙЛ байх болно.

Салбарын яамнаас олгодог ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ЗТ-3.2; ЗТ-3.4; ЗТ-3.5; ЗТ-3.6; ЗТ-4.1; ЗТ-7.1; ЗТ-7.2; ЗТ-7.3; ЗТ-7.4; ЗТ-8.1; ЗТ-9.1; ЗТ-9.2; ЗТ-11.1; ЗТ-11.2; ЗТ-11.3; заалтын дагуу үндсэн үйл ажиллагаа эрхэлж байна.

- Хот байгуулалт, төлөвлөлт - Тухайн хот тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохын тулд газар ашиглалт, хотын барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн судалгаанд суурилсан үе шат бүхий төлөвлөлт, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь хот тосгоны орчмын бүсийн экологийн тэнцвэрт байдал, инженерийн шугам сүлжээний эх үүсвэр, эдэлбэр газрын инженер-геологийн нөхцөлд хот байгуулалтын үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн архитектур, барилгажилт, тохижилт бүхий орон зайн зохистой бүтэц, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангасан төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.

## Төвийн бүсийн тулгуур төв ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 2020, 2030 он











Баруун бүсийн тулгуур төв ХОВД АЙМГИЙН ХОВД ХОТЫН
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 2020, 2030 он














# ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 2020 - 2035



## 02 НОГООН БАЙГУУЛАМЖ



## 03 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НЭГДСЭН ТРАСС





# СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 2020 / 2030

## НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮСЧЛЭЛ
/2020, 2030 оны төлөвлөлт/

### АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ

[illegible]

- [illegible]
- [illegible]
- [illegible]
- [illegible]
- [illegible]
- [illegible]




| Тэмдэглэгээ | | Нутаг дэвсгэрийн бүсчлэл | Талбай, га | Эзлэх хувь, % |
|---|---|---|---|---|
| | | **Орон сууц, олон нийтийн бүс** | | |
| 1.1 | | Орон сууцны бүс | 5.4 | 0.7 |
| 1.2 | | Хувийн орон сууцны бүс | 51.5 | 7.1 |
| 1.3 | | Гэр сууцны бүс | 56.2 | 7.8 |
| 1.4 | | Сургууль, цэцэрлэгийн бүс | 6.1 | 0.8 |
| 1.5 | | Эрүүл мэндийн төв, эмнэлэг | 0.6 | 0.1 |
| 1.6 | | Худалдаа үйлчилгээ | 11.5 | 1.6 |
| 1.7 | | Соёл, олон нийтийн төв | 6.0 | 0.8 |
| | | **Үйлдвэрлэлийн бүс** | | |
| 4.1 | | Хөнгөн үйлдвэр | 33.2 | 4.6 |
| | | **Инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс** | | |
| 2.1 | | Инженерийн барилга байгууламжийн бүс | 9.0 | 1.4 |
| 2.2 | | Инженерийн шугам сүлжээний бүс [illegible] | 34.9 | 4.8 |
| | | **Ногоон байгууламж, амралт, зугаа цэнгэлийн бүс** | | |
| 3.1 | | Нийтийн эдэлгээний ногоон байгууламж | 142.0 | 19.6 |
| 3.2 | | Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлт | 35.2 | 4.9 |
| 3.3 | | Тусгай зориулалттай цэцэрлэгжүүлэлт | 47.3 | 6.5 |
| | | **Хөдөө аж ахуйн бүс** | | |
| 5.1 | | Газар тариалан | 16.0 | [illegible] |
| 5.2 | | Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх газар | 25.8 | [illegible] |
| | | **Тусгай зориулалтын бүс** | | |
| 6.1 | | Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах бүс | 7.7 | 1.1 |
| 6.2 | | Хатуу хог хаягдлын цэг | 21.0 | [illegible] |
| | | **Бусад бүс** | | |
| 7.1 | | [illegible] | 4.2 | 0.6 |
| 7.2 | | Бусад талбай [illegible] | 117.7 | 20.1 |
| | | **Нөөц бүс** | | |
| 8.1 | | Амины орон сууцны нөөц бүс | 93.7 | 12.9 |
| 8.2 | | Орон сууцны нөөц бүс | 5.7 | 0.8 |
| 8.3 | | Сургууль, цэцэрлэгийн нөөц бүс | 3.1 | 0.4 |
| 8.4 | | Худалдаа үйлчилгээний нөөц бүс | 21.5 | 3.0 |
| 8.5 | | Хөнгөн үйлдвэрийн нөөц бүс | 27.6 | [illegible] |
| 8.6 | | Инженерийн барилга байгууламжийн нөөц бүс | 3.6 | 0.5 |
| | | **Нийт талбай** | 724.5 | 100 |



ХЭНТИЙ АЙМАГ, БАТНОРОВ СУМ, БЭРХ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

# ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэсэн тухайн хэсгийн талбайн өндөржилт, зай хэмжээ, инженерийн шугам сүлжээний шийдэл, ногоон байгууламж, орчны тохижилтыг норм дүрмийн шаардлагад нийцүүлэн иргэдийн оролцоотой төлөвлөнө.

## УЛААНБААТАР ХОТ - ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН




















# СҮХБААТАР СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сүхбаатар аймгийн Баруун - Урт сум



Сүхбаатар соёл амралтын хүрээлэнгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах даалгаварт төлөвлөлт хийх талбай 75 га ба төлөвлөлтийн явцад нэмэлтээр 171 га талбай, нийт 246 га талбайг бүсчилэн төлөвлөв.







## Харагдах байдал







# ТӨВ АЙМГИЙН 1000 АЙЛИЙН ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ

Төв аймаг, Зуунмод хот



Ерөнхий төлөвлөгөө



Гадна инженерийн шугам сүлжээний зураг



# ХАЛЗАН ТОЛГОЙ ДАХЬ ЦАНЫН БААЗ-ын ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэнтий аймаг, Дадал сум




| Тодорхойлолт | | | |
|---|---|---|---|
| № | Өрөөний нэр | Хүчин чадал | Тайлбар |
| 1 | Цанын баазын захиргаа, үйлчлүүлэгчдийн барилга | 100 хүн | Эхний ээлж |
| 2 | I-р зам | 343.3м | Эхний ээлж |
| 3 | II-р зам | 482.5м | Эхний ээлж |
| 4 | Сургалтын зам | 200.0м | Эхний ээлж |
| 5 | III-р зам | 720.8м | Дунд хугацаанд |
| 6 | Цанын гүйлтийн зам А цэг | 403.2м | Эхний ээлж |
| 7 | Талбай | 51.0 м | Эхний ээлж |
| 8 | Дээшээ өгсөх лифт | 320.0 м | Эхний ээлж |
| 9 | Тэшүүрийн талбай / каток | 486.0 м2 | Эхний ээлж |
| 10 | Хүүхдийн тоглоомын талбай | 123.0 м2 | Эхний ээлж |
| 11 | Тюбингийн зам 124.0м | 124.0м | Дунд хугацаанд |
| 12 | Чаргаар гулгах талбай | 4990.0 м2 | Эхний ээлж |
| 13 | Сноубордын парк | 3523.1 м2 | Дунд хугацаанд |
| 14 | Авто зогсоол | 7840.0 м2 | Эхний ээлж |
| 15 | Авто зогсоол | 821.0 м2 | Эхний ээлж |
| 16 | Рашаан | - | Одоо байгаа |
| 17 | Бусад барилга байгууламжид шаардлагатай талбай | - | Дунд хугацаанд |
| 18 | Гэр зочид буудал | - | Дунд хугацаанд |

## "Цанын бааз"-ын захиргаа, үйлчилгээний барилга



## Нүүр тал



## Давхрын байгуулалт:



## Харагдах байдал:



# МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙН ГАЗРЫН ГАДАРГУУГИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### ХЭНТИЙ АЙМАГ, БАТНОРОВ СУМ, БЭРХ ХОТ




## ТОДОРХОЙЛОЛТ

| Д/д | Барилга байгууламжийн нэр | Хэмжих нэгж | Давхрын тоо | Талбай /м2/ | Барилгын эзэлхүүн /м3/ | Барилгын тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| Эхний ээлж 1-р үе /2020он/ /10.0га/ | | | | | | | |
| 1 | Сургалт судалгааны төв | объект | 2 | 959.1 | 2023.1 | 1 | Шинэчлэгдэн засварлах |
| 2 | Мэдээллийн төв | объект | 1 | 464 | 2088 | 1 | Төлөвлөх бүй |
| 3 | Музей | объект | 2 | 796 | 2605 | 1 | Шинэчлэгдэн засварлах |
| 4 | Зуухны барилга | объект | 1 | | | 1 | Төлөвлөх бүй |
| 5 | ХТП | объект | 1 | - | - | 1 | Шинэчлэгдэн засварлах |
| Эхний ээлж 2-р үе | | | | | | | |
| 6 | Уулын хэмжээрийн төв | объект | 1 | 215.8 | 1942.2 | 1 | Төлөвлөх бүй |
| 7 | Вентилятор | объект | 1 | 108 | 689.6 | 1 | Одоо байгаа |
| 8 | Дотуур байр | объект | 3 | | | 1 | Төлөвлөх бүй |
| 9 | Зочид буудал | объект | 3 | | | 1 | Төлөвлөх бүй |
| 10 | Ажлын ам | объект | 1 | 155.6 | - | 1 | Одоо байгаа |
| 11 | [illegible] | объект | 1 | 309.5 | - | 1 | Одоо байгаа |
| 12 | Механик цех | объект | 1 | 480.9 | - | 1 | Одоо байгаа |
| 13 | Авто зогсоол | талбай | - | 0.28 /га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 14 | Баяжуулах фабрик | объект | 3 | 1288.9 | - | 1 | Одоо байгаа |
| Бэрхийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө | | | | | | | |
| 15 | [illegible] | талбай | - | 0.68/га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 16 | Усан тоглоом, усан парк | талбай | - | 1.05/га | - | - | Төлөвлөх бүй |
| 17 | Задгай театр | талбай | | 1.08/га/ | | | Төлөвлөх бүй |
| 18 | Спорт талбай | талбай | | 0.45/га/ | | | Төлөвлөх бүй |
| 19 | Авто зогсоол | талбай | | 0.1/га/ | | | Төлөвлөх бүй |
| 20 | Авто зогсоол | талбай | - | 0.5/га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 21 | Хүүхдийн цанын зам | талбай | - | 150м | - | - | Төлөвлөх бүй |
| 22 | Цанын зам 1 | талбай | - | 630м | - | - | Төлөвлөх бүй |
| 23 | Цанын зам 2 | талбай | | 548м | | | Төлөвлөх бүй |
| 24 | Гольфын талбай | талбай | - | 5.1/га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 25 | Мини усан парк | талбай | - | 0.4/га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 26 | Амралт зугаалгын талбай | талбай | - | 1.56/га/ | - | - | Төлөвлөх бүй |
| 27 | Усан парк | талбай | - | - | - | - | Төлөвлөх бүй |
| 28 | [illegible] | талбай | - | 126.1 | - | - | Төлөвлөх бүй |
| 29 | ХТП | объект | 1 | 83.6 | 334.4 | 1 | Төлөвлөх бүй |
| 30 | ХТП | объект | 1 | 83.6 | 334.4 | 1 | Төлөвлөх бүй |



Хот суурин газрыг дахин хөгжүүлэхэд архитектур, хот байгуулалт, төлөвлөлт, барилга байгууламжид тавигдах шаардлагад нийцүүлэн хот суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөх, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах цогц үйлчилгээг төлөвлөлтөндөө тусгана.

## ХЭНТИЙ АЙМАГ, ЧИНГИС ХОТЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

















## ХЭНТИЙ АЙМГИЙН СУМДЫН ТӨВИЙН БАРИЛГАЖИЛТ, ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

ДАРХАН СУМ



БАЯН-МӨНХ СУМ



ДАДАЛ СУМ



БАЯНХУТАГ СУМ



ЦЭНХЭРМАНДАЛ СУМ



НОРОВЛИН СУМ



БАРИЛГАЖИЛТЫН ТӨСӨЛ, ХОТ СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

БАТНОРОВ СУМ



МӨРӨН СУМ



ЖАРГАЛТХААН СУМ



ӨМНӨДЭЛГЭР СУМ



ГАЛШАР СУМ



ДЭЛГЭРХААН СУМ



# СҮХБААТАР АЙМГИЙН СУМДЫН ТӨВИЙН БАРИЛГАЖИЛТ, ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

## БАЯНДЭЛГЭР СУМ



## АСГАТ СУМ



## ОНГОН СУМ



## ТҮВШИНШИРЭЭ СУМ



## УУЛБАЯН СУМ



## СҮХБААТАР СУМ



## МӨНХХААНСУМ



## ТҮМЭНЦОГТ СУМ



## НАРАН СУМ



# ГЭР ХОРООЛЛЫГ ДАХИН ТӨЛӨВЛӨХ БАРИЛГАЖУУЛАХ ТӨСӨЛ /23,3га/

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо















Бүх төрлийн барилга байгууламж, тэдгээрийн гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын зураг төслийг ажил эхлэхийн өмнөх шатны судалгаа, тооцоо, техникийн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулна. Зураг төсөл нь захиалагчийн хүсэл сонирхолд нийцсэн, холбогдох хууль тогтоомж, норм стандартын шаардлагагыг хангасан, хөрөнгө оруулалтын үр өгөөжтэй, архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдлүүд,тохижилт , материал сонголт нь харилцан уялдаатай, орчинтойгоо зохицсон шинэлэг санааг тусгасан төлөвлөлттэй байна.

## GENESIS CAPITAL SUN CITY ОФФИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА

Сүхбаатар аймаг,
Баруун-урт хот










## ОРОН СУУЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА




THE ONE RESIDENCE ОРОН СУУЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ



Шилмэл шилтгээн ХХК-ийн Дүнжингарав орон сууцны цогцолбор /БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ/



# ШИНЭ МОНГОЛ ДЭЭД СУРГУУЛИЙН БАРИЛГА

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ




4-Р ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ









# SPRING TOWN ОФФИС, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ



1-Р ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ





# ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВ, ОФФИСЫН БАРИЛГА

Улаанбаатар хот,
Хан-уул дүүргийн 11-р хороо



## 1-р давхрын байгуулалт



## 2-р давхрын байгуулалт







# БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ

## БСБ КОРПОРЭЙШН ХХК-НЫ АГУУЛАХЫН БАРИЛГА

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

















# НИСЭХ ОНГОЦНЫ БУУДЛЫН ЗОРЧИГЧИЙН ХООЛ БЭЛТГЭХ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ КАТЕРИНГИЙН БАРИЛГА

Төв аймаг, Сэргэлэн сум, Хөшгийн хөндий




Огтлол:



1-р давхрын байгуулалт:



## ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ /НУТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОН/

Хэнтий,Сүхбаатар аймгийн сумдад



### 1-р давхрын байгуулалт



### 2-р давхрын байгуулалт









# МОНГОЛ ТӨРИЙН ИХ ХУРАЛДАЙН ОРД ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР

Хэнтий аймаг, Биндэр сум













# ШИХИХУТУГ - ИХ ЗАСАГ ЦОГЦОЛБОР
Хэнтий аймаг, Норовлин сум









## "ДОТУУР БАЙР" /BM DORMITORY/
Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх хот




Захиалагч:

УУХҮЯ-ны харьяа Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв төслийн нэгж

Дотуур байрын барилга нь цутгамал төмөр бетон арагт бүтэцтэй, тэнхлэгээрээ 13.5х39.6м харьцаатай, 3 давхар барилга.

### 1-р давхрын байгуулалт



### 2-р давхрын байгуулалт








UPI
URBAN PLANNING INSTITUTE
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭЛЭН

# БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ

## 8 АЙЛЫН ОРОН СУУЦ

Дорноговь аймаг,Даланжаргалан сум













# 150 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ
Баянзүрх дүүрэг







## ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ОФФИСИЙН БАРИЛГА

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг









1-р давхрын байгуулалт



2-р давхрын байгуулалт



Улс, бүс, орон нутаг, салбарын түвшинд үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, чөлөөт бүс, дэд бүтцийн чиглэлээр дэвшүүлсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд суурь судалгаа, тооцоо, төлөвлөлт, хэрэгжилтийн менежмент, техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулна.

ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК




## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- Нийт талбай 214 га
- Дэд бүтэц - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт
- Үйлдвэрлэлийн бүс /55га/ - Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Суурьшлын бүс /22,5га/ - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт
- Хөнгөн үйлдвэрлэлийн МУ-ын нэгдсэн стандартыг бий болгох
- Технологийн судалгааны төв байгуулагдсанаар бүтээгдэхүүний чанарын сайжруулалт байнга хийгдэнэ.
- Үйлдвэрлэлээс гарч буй хог хаягдлыг бууруулах
- Орон нутгийн засаг захиргааны нэгдсэн үйл ажиллагаа
- Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн мөчлөг бүхий иж бүрэн парк болно.









ДЭЛХИЙН МЯНГАНЫ СУУТ ХҮН – ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН
ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН ТӨСӨЛ




## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Монгол улс - Дэлхийн түүхийн салшгүй хэсэг:

- XIII зуунд дэлхий нийтийг нэгтгэн захирсан Монголын эзэнт гүрнийг байгуулсан Их эзэн Чингис хаан - Монголчууд бидний бахархал.
- Их эзэн Чингис хааны өлгий нутаг, төрсөн газар, ариун тахилгат онгон шүтээн, дэлхийн нийслэл Хархорум хот, залгамж их хаадын голомт Монгол нутаг.
- Дэлхийн мянганы суут хүнээр Их эзэн Чингис хааныг тодруулсан.
- /Вашингтон пост 1995.12.31 -ний өдөр зарласан/
- Монголчуудын түүх өв соёл, нүүдэлчин ахуй заншил, үзэсгэлэнт байгалийн унаган төрх нь дэлхий нийтийн анхаарлыг ихээр татах болсон.
- Их эзэн Чингис хаан - хүн төрөлхтний цоо шинэ нийгмийг цогцлоон бүтээгч аугаа их архитектор мөн.
- Энэ бүхэн Монгол улсад дэлхийн сая сая жуулчдын урсгалыг татах болно

Одоогоос найман зууны тэртээ 1206 онд Их хуралдайгаар Тэмүүжинг эзэн хаанд өргөмжилснөөрөө хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд түүхэн онцгой үүрэг гүйцэтгэсэн нь Чингис хаан Монголын олон аймаг, угсаатныг тухайн үеийн нийгмийн харилцаа, үндэстнийхээ ертөнцийг үзэх үзэлд зохицсон улс төр, хууль цаазын бодлогоор нэгдмэл удирдлагад нэгтгэн бэхжүүлэхийг хичээн эрмэлзэн төрт ёсны үзэл санаа он цаг улирах тусам улам бүр тодорч, орчин үеийн соёлт ертөнцийн анхаарлыг бүр ч ихээр татах болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Чингис хаан-Тэмүжиний мэндэлсэн огноог албан ёсны болгож ёсчлох тухай 2012 оны нэгдүгээр сарын 9-ний 04 тоот зарлигтаа билгийн тооллын гуравдугаар жарны усан морин жил буюу 1162 оны өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдөр хэмээн үзсүгэй. Их хааны мэндэлсэн өдрийг "Монгол бахархлын өдөр" гэж нэрийдэж бүх нийтээр ёслон тэмдэглэж байсугай гэсэн юм.

Америкийн "Вашингтон Пост" сонин 1995 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийн дугаартаа өнгөрсөн Мянганы хүнээр Чингис хааныг тодруулж "Өнгөрсөн мянган жилд гарсан хамгийн том үйл явдал бол цэвэр нэг л үндэстэн дэлхий даяар сүр хүчээ бүрэн төгс илтгэж чадсан явдал бөлгөө. Тэр болон түүний залгамжлагчид Ази, Европ тивийг хамарсан чөлөөт худалдааны асар өргөн уудам бүс бүрэлдүүлж, Дорно, Өрнийн соёл иргэншлийн хэлхээ холбоог бэхжүүлж өгсөн юм. Тэд Интернэт бүтээгдэхээс аль тэртээх 700 жилийн өмнө дэлхийг холбосон харилцаа холбооны сүлжээг анх бий болгосон байна. Тэрээр хүн хүч, шинэ арга технологийг сүлжилдүүлэн дэлхий ертөнцийг ойртуулж нягтруулсан хүн" хэмээн үнэлэн дүгнэсэн байдаг.




ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОЙРОГ ЗАМ /Эхний ээлж/

Дэлхийн хөгжилд хамгийн хүчирхэг нөлөө үзүүлсэн мянганы суут хүнээр Чингис хааныг тодруулсан явдал нь Хүн төрөлхтний хөгжил, дэлхийн даяаршлын чиг хандлага Чингис хааны үйлсийг тунгаан үзэж үнэлэх үндэс шалгуур болсон байдаг.

1.Чингис хааны байгуулсан Их Монгол улсын төрийн бодлого тэлж тив дамнасан дэлхийн эзэнт гүрнийг байгуулахад хүргэсэн юм. Өргөн утгаар авч үзвэл: улс хоорондын харилцааг өргөтгөж, улс үндэстнүүдийг эв эетэйгээр аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, чөлөөт худалдааг хөгжүүлэх, шударга ёсыг тогтоох, хуулийн тэгш байдлыг хангах гэсэн тэмүүлэл нь түүний үзэл санааны цөм нь байв.

2.Чингисийн үйл хэрэг шинэ шинэ улс, үндэстэн бүрэлдэн тогтноход шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм. Ийм болохоор нэгдсэн тулгар төр болон дэлхийг засан төвшитгөх үйл хэргийг хэрэгжүүлэхдээ баримталсан Чингис хааны цэцэн билгийн оҳь сургаалыг монголчууд төдийгүй ертөнц дахин судлах болов.

3.Чингис хаан Их Монгол улсыг байгуулсан төдийгүй Монгол үндэстэн бүрэлдэх нөхцөлийг хангаж өгсөн гавьяатай. Өнөөдөр Монголчууд үндэстнийхээ хувьд бас оршин тогтож байна.

4.Чингис хаан болон түүний үе залгамжлагч Өгөөдэй хаан, Хубилай хааны байлдан дагуулалын үед Энэтхэг, Вьетнамаас Унгар, Солонгосоос Балканы хойг хүртэлх асар уудам нутгийг эзэлж Монголын Их Эзэнт гүрэн дэлхийн газрын зургийг ахин шинээр үйлдэж саланги тусгаар хаант улсуудыг нэгтгэн зангидах ухаалаг тасралтгүй бодлого явуулсан суу билигтнүүд байсан.





# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ОРОН СУУЦНЫ 2,3-Р ХОРООЛЛЫН ШИНЭЧЛЭН БАРИЛГАЖУУЛАХ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

БАЙРШЛЫН СХЕМ

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

















# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОРЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД




















МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ЭКО ГАЛАРЕЙ



Барилга байгууламжийн гадна тал, дотоод орон зайн архитектур төлөвлөлт, урлаг, уран сайхан, гоо зүйн шийдлийг орчинтой нь уялдуулан шинэ дэвшилтэт материал технологи, хийц, хэлбэр, зохиомж, өнгө будаг, гэрэлтүүлгийг цогцоор нь шийдвэрлэнэ.

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БАРИЛГЫН ИНТЕРЬЕР
Хэнтий аймаг, Дэлгэрхаан сум













# ЭНХ ТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨНИЙ ЗАМ ДАГУУХ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ОРОН СУУЦНЫ БАРИЛГУУДЫН ЭКСТРЬЕРИЙН ШИЙДЭЛ




Ерөнхий харагдах байдал





Тагт, цэцгийн тавиурын шинэчлэлт






## И-МОНГОЛИА БОЛОН 11-11 ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНХИМ













## "СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ" /ИНТЕРЬЕР/

Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх хот










## МОНГОЛ ТӨРИЙН ИХ ХУРАЛДАЙН ОРД ӨРГӨӨ ЦОГЦОЛБОР ХЭНТИЙ АЙМАГ, БИНДЭР СУМ









## ШИХИХУТУГ - ИХ ЗАСАГ ЦОГЦОЛБОР ХЭНТИЙ АЙМАГ, НОРОВЛИН СУМ









**Зураг төсөл зохиогчийн хяналт** Зохиогчийн боловсруулсан зураг төслөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл шатанд зураг төсөл зохиогчийн хяналтыг дүрмээр олгогдсон эрх, үүргийн хүрээнд гүйцэтгэж захиалагч, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч байгууллагуудын харилцан хамаарал, уялдаа холбоог ханган хамтран ажиллана.

**Захиалагчийг төлөөлөн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ** Хөрөнгө оруулагч, захиалагчийн хүсэлтээр өөрийн оролцоогүй, бусад байгууллагын боловсруулсан зураг төслөөр баригдах барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар гэрээний үндсэн дээр захиалагчийн чиг үүргийг төлөөлөн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.








Холбоо барих

Утас: +976-11319078, +976-99185670
И-мэйл: info@upinst.mn Вэб сайт: www.upinst.mn

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жуулчны гудамж, Капитал төв, 1202 тоот